

Монголын Үнэт Цаасны Бирж ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн
39/21 тоот тогтоолын хавсралт



АРИЛЖААНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

ЖУРМЫН АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ.....	3
1.1. Зорилго	3
1.2. Хамрах хүрээ	3
1.3. Хүчин төгөлдөр байдал.....	3
ХОЁР. БИРЖИЙН АРИЛЖААНЫ ГИШҮҮНЧЛЭЛ.....	4
2.1. Ерөнхий зүйл	4
2.2. Арилжааны гишүүн, түүний үйл ажиллагаа.....	4
ГУРАВ. АРИЛЖААНЫ ГИШҮҮНД ТАВИГДАХ ШАЛГУУР	6
3.1. Ерөнхий зүйл	6
3.2. Ерөнхий шалгуур	6
3.3. Санхүүгийн шалгуур	7
3.4. Үйл ажиллагааны шалгуур	7
3.5. Арилжааны гишүүнд тавигдах шалгуураас хөнгөлөх, чөлөөлөх	8
ДӨРӨВ. АРИЛЖААНЫ ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ	9
4.1. Арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргах.....	9
4.2. Арилжааны гишүүнээр элсүүлэх.....	11
4.3. Шимтгэл, хураамж	12
ТАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ	13
5.1. Арилжааны гишүүнд тавих хяналт.....	13
ЗУРГАА. ГИШҮҮНЧЛЭЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ.....	14
6.1. Ерөнхий зүйл	14
6.2. Гишүүнчлэлийн гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэх.....	14
6.3. Арилжааны гишүүний хүсэлтээр гишүүнчлэлийн гэрээг цуцлах	15
ДОЛОО. ХАВСРАЛТ.....	16
Хавсралт 1. Өргөдлийн маягт	16
Хавсралт 2. Ажилтнуудын анкет	20
Хавсралт 3. Гарын үсгийн баталгааны маягт.....	22
Хавсралт 4. Арилжааны гишүүнчлэлийн гэрээний үлгэрчилсэн загвар.....	23

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Зорилго

1.1.1. Энэ журмын зорилго нь “Монголын үнэт цаасны бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн арилжааны гишүүнчлэлийн ажиллагааны үндсэн зарчим, арилжааны гишүүнээр элсэх үйл явц болон арилжааны гишүүдэд тавигдах шалгуурыг тодорхойлж, өргөдөл гаргагчийг өргөдлийг шийдвэрлэх, арилжааны гишүүнээр элсүүлэх, арилжааны гишүүнчлэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, арилжааны гишүүдэд хяналт тавих, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх болон хасахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамрах хүрээ

1.2.1. Энэ журмыг Бирж болон түүний арилжааны гишүүнчлэлтэй үнэт цаасны компани дагаж мөрдөнө.

1.2.2. Бирж болон түүний арилжааны гишүүнчлэлтэй үнэт цаасны компанийн харилцан хүлээх эрх, үүрэг нь энэ журмаас гадна Арилжааны гишүүнчлэлийн гэрээ болон Биржээс дээрх харилцааг зохицуулахаар баталсан бусад журам, баримт бичгүүдээр зохицуулагдана.

1.2.3. Арилжааны гишүүнчлэлтэй үнэт цаасны компани Биржийн арилжаанд оролцохтой холбогдсон харилцааг Биржийн арилжааны журмаар, төлбөр тооцоо гүйцэтгүүлэхтэй холбогдсон харилцааг Биржийн тооцооны үйл ажиллагааны журмаар тус тус нарийвчлан зохицуулна.

1.3. Хүчин төгөлдөр байдал

1.3.1. Энэ журам, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “Биржийн ТУЗ” гэх) баталж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.4-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) батламжилна.

1.3.2. Хороо өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам нь Хороо энэ журмыг батламжилсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.3.3. Энэ журмаар зохицуулагдаагүй бусад харилцаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмууд болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтлан зохицуулна.

1.3.4. Бирж, түүний гүйцэтгэх удирдлага энэ журам болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад журам, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

1.3.5. Энэ журмын хавсралтууд журмын салшгүй хэсэг байна.

ХОЁР. БИРЖИЙН АРИЛЖААНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

2.1. Ерөнхий зүйл

- 2.1.1. Биржийн арилжааны гишүүнчлэл нь аливаа үнэт цаасны компани Биржтэй арилжааны гишүүнчлэлийн гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжих бөгөөд тус гэрээнд Биржийн болон үнэт цаасны компанийн гүйцэтгэх удирдлага гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулна.
- 2.1.2. Арилжааны гишүүн нь дараах эрхүүдийг Биржээс авч Биржийн арилжаанд оролцох боломжтой байна. Үүнд:
- i. Энгийн арилжаанд оролцох эрх
 - ii. Үүсмэл хэрэгслийн арилжаанд оролцох эрх
- 2.1.3. Энгийн арилжаанд оролцох эрх гэж тухайн үнэт цаасны компани ҮЦЗЗТХ-ийн 5.1.1 – 5.1.7-д заасан үнэт цаасыг Биржээр дамжуулан арилжих эрхийг хэлнэ.
- 2.1.4. Үүсмэл хэрэгслийн арилжаанд оролцох эрх гэж тухайн үнэт цаасны компани ҮЦЗЗТХ-ийн 5.1.8-д заасан үнэт цаасыг Биржээр дамжуулан арилжих эрхийг хэлнэ.
- 2.1.5. ҮЦЗЗТХ-ийн 5.1.9 болон 5.1.10-т заасан үнэт цаасыг арилжихтай холбогдсон эрхийг Бирж үнэт цаас тус бүрээр олгож болох бөгөөд тухай бүр аливаа үнэт цаасны компанид эрх олгох эсэхийг шийдвэрлэнэ.
- 2.1.6. Арилжааны гишүүн нь энэ журмын 2.1.2-т зааснаас гадна Зах зээл үүсгэгчээр ажиллах нэмэлт гэрээ байгуулан ажиллаж болно.
- 2.1.7. Энэ журмын 2.1.2-т заасан эрхийн аль нэгийг авсан арилжааны гишүүн нь энэ журмын 2.1.2-т заасан бусад эрхийг авахаар хүсэлтэй гаргахдаа энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан үе шатуудыг мөрдөх шаардлагагүй бөгөөд зөвхөн Хавсралт 1-т заасан өргөдлийн маягтыг бөглөн ирүүлж, Биржийн гүйцэтгэх удирдлага тухайн хүсэлтийг шийдвэрлэнэ.

2.2. Арилжааны гишүүн, түүний үйл ажиллагаа

- 2.2.1. Арилжааны гишүүн нь ҮЦЗЗТХ-ийн 24.1-т заасан холбогдох тусгай зөвшөөрлийг Хорооноос авсан үнэт цаасны компани байх бөгөөд Биржийн арилжааны журамд заасан арилжаанд оролцогчийн холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.2.2. Арилжааны гишүүн нь Биржийн бусад журам болон Арилжааны гишүүнчлэлийн гэрээнд зааснаас гадна дараах нийтлэг эрхийг эдэлнэ. Үүнд:
- i. Өөрийн компанийн арилжааны мэдээ болон бусад холбогдох мэдээллийг гаргуулан авах
 - ii. Биржийн арилжааны болон зах зээлтэй холбоотой нийтэд үнэ төлбөргүй тараагдах мэдээ, мэдээллийг гаргуулан авах

- iii. Биржид санал хүсэлт гаргах, тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу авах.
- 2.2.3. Арилжааны гишүүн нь Биржийн бусад журам болон Арилжааны гишүүнчлэлийн гэрээнд зааснаас дараах нийтлэг үүргийг хүлээнэ. Үүнд:
- i. Арилжааны гишүүнчлэлийн гэрээ болон Биржийн журмуудад заасан шалгуур, шаардлагуудыг тогтмол биелүүлж ажиллах
 - ii. Шимтгэл, хураамжийг холбогдох журам болон нэхэмжлэхэд заасан хугацаанд төлөх
 - iii. Биржид бүртгэлтэй мэдээлэл өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөлтийн талаар Биржид тогтмол мэдээлэл хүргүүлж байх
 - iv. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй бүхий л хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах
 - v. Биржээс шаардсан тохиолдолд арилжаанд оролцох эрхээ тодорхой хугацаанд түдгэлзүүлсэн, гишүүний үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол тухайн гишүүний үүргийг бүхэлд нь болон хэсэгчлэн биелүүлэхийг зөвшөөрсөн 1 (нэг)-ээс доошгүй арилжааны гишүүнтэй эрх, үүрэг шилжүүлэх тухай гэрээ байгуулах
- 2.2.4. Арилжааны гишүүн нь Арилжааны гишүүнчлэлийн гэрээний хугацаанд дараах мэдээлийг Биржид улирал тутамд ирүүлэх үүрэгтэй. Үүнд:
- i. Санхүүгийн тайлан
 - ii. Үйл ажиллагааны тайлан
- 2.2.5. Арилжааны гишүүн нь гишүүнчлэлийн гэрээний хугацаанд дараах мэдээлийг Биржид тухай бүр ирүүлэх үүрэгтэй. Үүнд:
- i. Хорооноос авсан тусгай зөвшөөрлийн сунгалт, нэмж авсан тусгай зөвшөөрлийн талаарх болон бусад өөрчлөлт
 - ii. Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл
 - iii. Компанийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан ХЭХ-ийн болон ТУЗ-ийн шийдвэр
 - iv. Компанийн нэр, хаяг болон бусад холбоо барих мэдээлэл өөрчлөгдсөн бол энэ тухай мэдээлэл
 - v. Компанийн дүрэм болон бусад Биржид бүрдүүлж өгсөн баримт бичиг дэх аливаа мэдээлэл өөрчлөгдсөн бол энэ тухай мэдээлэл
 - vi. Клирингийн гишүүнтэй гэрээ байгуулсан эсвэл цуцалсан бол энэ тухай мэдээлэл

ГУРАВ. АРИЛЖААНЫ ГИШҮҮНД ТАВИГДАХ ШАЛГУУР

3.1. Ерөнхий зүйл

3.1.1. Арилжааны гишүүнээр элсэх этгээд нь дараах шалгуурыг хангасан байх бөгөөд Арилжааны гишүүнчлэлтэй байх хугацаанд тогтмол хангаж ажиллана. Үүнд:

- i. Ерөнхий шалгуур
- ii. Санхүүгийн шалгуур
- iii. Үйл ажиллагааны шалгуур

3.1.2. Энэ бүлэгт заасан бүх шалгуурыг хангасан байх нь тухайн этгээдийг шууд Биржийн арилжааны гишүүнээр элсүүлэх үндэслэл болохгүй бөгөөд өргөдөл гаргагчийн өргөдлийг хүлээн авч, арилжааны гишүүнээр элсүүлэх эсэх тухай асуудлыг Бирж өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.

3.1.3. Бирж шаардлагатай гэж үзвэл энэ бүлэгт заагаагүй нэмэлт шалгуурыг арилжааны гишүүн эсвэл өргөдөл гаргагчид тавьж болно.

3.1.4. Өргөдөл гаргагч нь арилжааны гишүүнд тавигдах шалгуурыг хангах эсэхийг урьдчилан тодорхойлох зорилгоор Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгжээс албан бус зөвлөмж авч болох бөгөөд уг зөвлөмжийг талууд нууцлах үүрэгтэй.

3.2. Ерөнхий шалгуур

3.2.1. Арилжааны гишүүн нь дараах ерөнхий шалгуурыг хангасан байна. Үүнд:

- i. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, улсын бүртгэл, татвар, нийгмийн даатгалын болон бусад эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн хуулийн этгээд байх
- ii. ҮЦЗЗТХ болон Хорооны холбогдох журамд заасны дагуу ҮЦЗЗТХ-ийн 24.1.1, 24.1.2 эсхүл 24.1.5-д заасан тусгай зөвшөөрлийн дор хаяж аль 1 (нэг)-ийг эзэмшиж байх
- iii. Арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргахаас өмнөх 1 (нэг) жилийн хугацаанд татан буулгах, дампууруулах тухай шийдвэр эрх бүхий байгууллагаас хүлээн аваагүй байх
- iv. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хохироох аливаа хэрэг, маргаанд холбогдоогүй байх
- v. Тооцооны үйлчилгээ үзүүлэх ерөнхий гишүүнийг сонгон гэрээ байгуулах

3.2.2. Арилжааны гишүүн нь тооцооны үйлчилгээ авах ерөнхий гишүүнийг бусдаас хамааралгүйгээр сонгон Клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулна. Энэхүү гэрээ нь 2 талт гэрээ бөгөөд Арилжааны гишүүн болон Тооцооны ерөнхий гишүүн хоорондын харилцаанд Бирж хамааралгүй болно.

3.3. Санхүүгийн шалгуур

3.3.1. Арилжааны гишүүн нь дараах санхүүгийн шалгуурыг хангасан байна. Үүнд:

- i. Хорооны холбогдох журамд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн болон бусад санхүүгийн шалгуурыг хангаж байх
- ii. Цэвэр хөрөнгийн дүн брокер, дилерийн эрхтэй гишүүдийн хувьд 300 сая төгрөгөөс доошгүй байх
- iii. Биржээс шаардсан барьцаа, дэнчин болон эрсдэлийн сангийн хөрөнгийг байршуулах чадамжтай байх

3.4. Үйл ажиллагааны шалгуур

3.4.1. Арилжааны гишүүн нь үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортой явуулахын тулд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- i. Биржийн арилжаанд оролцоход шаардлагатай техник, хангамжтай байх
- ii. Биржийн арилжаанд оролцох, Биржтэй харилцах хүний нөөцийн чадамжтай байх
- iii. Биржийн арилжаанд оролцох болон түүнтэй холбогдон гарах бусад харилцааг зохицуулах журам, бусад баримт бичгийг баталсан байх

3.4.2. Арилжааны гишүүн нь техник, технологийн хувьд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- i. Биржийн мэдээллийн технологи хариуцсан нэгжээс гаргасан шаардлагыг хангасан үзүүлэлт бүхий техник хэрэгсэл, программ хангамжийг ашиглах
- ii. Бирж болон Биржид сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага хоорондын гэрээнд заасан техникийн нөхцөлийг бүрдүүлж, Биржийн арилжаа, тооцооны системд сүлжээгээр холбогдох

3.4.3. Арилжааны гишүүн нь хүний нөөцийн хувьд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- i. Гүйцэтгэх захирал болон биржийн арилжаанд оролцох, зуучлах ажилтнууд нь Монгол улсын иргэншилтэй, байнга оршин суудаг байх
- ii. Гүйцэтгэх удирдлага болон биржийн арилжаанд оролцох, зуучлах ажилтнууд нь үнэт цаасны зах зээл, түүнтэй ижил төрлийн салбарт ажиллаж байсан туршлагатай, сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд үнэт цаасны зах зээлд холбогдолтой гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх
- iii. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх бүхий 5 (тав)-аас доошгүй ажилтантай байх

3.4.4. Арилжааны гишүүн нь зохицуулалтын хувьд дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- i. Брокер, дилерийн үйлчилгээ эрхлэх үндсэн үйл ажиллагааны журам боловсруулж, мөрдөж байх
- ii. Эрсдэлийн удирдлагын журам боловсруулж, мөрдөж байх
- iii. Хорооны холбогдох журамд заасан үйл ажиллагаа явуулахад шаардлагатай журам болон бусад баримт бичгийг баталсан байх
- iv. Биржээс тухай бүр шаардсан бусад баримт бичгийг боловсруулж мөрдөж

3.5. Арилжааны гишүүнд тавигдах шалгуураас хөнгөлөх, чөлөөлөх

3.5.1. Өргөдөл гаргагч нь Биржийн гүйцэтгэх удирдлага зөвшөөрсөн тохиолдолд дараах хэлбэрээр арилжааны гишүүнд тавигдах шалгуураас хөнгөлөгдөж эсхүл чөлөөлөгдөж болно. Үүнд:

- i. Өргөдөл хянах болон элсэлтийн хураамжаас хөнгөлөгдөх эсвэл чөлөөлөгдөх
- ii. Арилжааны гишүүнд тавигдах шалгуурыг тодорхой хугацааны дотор хангахаар хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх
- iii. Зарим бүрдүүлэх баримт бичгээс чөлөөлөгдөх

3.5.2. Өргөдөл гаргагч нь арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргахаас өмнө Биржид энэ журамд заасан шалгуур, шаардлагаас чөлөөлүүлэх эсвэл хөнгөлөгдөх хүсэлт гаргаж болох бөгөөд тухайн асуудлаар аливаа шийдвэр Биржээс авсны дараа арилжааны гишүүнээр элсэх өргөдлөө Биржид ирүүлнэ.

3.5.3. Энэ журмын 3.5.2-т заасан хүсэлтийг өргөдөл гаргагчийн эрх бүхий албан тушаалтан гаргах бөгөөд тус хүсэлтэд чөлөөлүүлэх эсвэл хөнгөлөгдөхийг хүссэн шаардлага, түүний тайлбар, үндэслэлийг тусгана.

3.5.4. Бирж арилжааны гишүүнд тавигдах шалгуур, шаардлагаас чөлөөлүүлэх эсвэл хөнгөлөгдөх хүсэлтийг ажлын 10 (арван) хоногт багтан шийдвэрлэж өргөдөл гаргагчид шийдвэрийг хүргүүлнэ. Өргөдөл гаргагч тус шийдвэрт гомдол гаргах эрхгүй байна.

ДӨРӨВ. АРИЛЖААНЫ ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ

4.1. Арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргах

4.1.1. Арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргагч нь Хавсралт 1-т заасан маягтын дагуу Биржийн арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргах бөгөөд Бирж тухайн өргөдлийг хүлээн авч, дараах баримт бичгийг бичгээр ирүүлэх тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Үүнд:

- i. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- ii. Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар, дүрэмд оруулсан боловч улсын бүртгэлд бүртгэгдээгүй байгаа нэмэлт өөрчлөлт
- iii. Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар
- iv. Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 (гурав) хүртэл жилийн санхүүгийн тайлан
- v. Компанийн үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, харилцагчтай байгуулах гэрээний төсөл
- vi. Арилжаанд оролцох эрх авах, эсвэл эрх авсан ажилтны хувьд нууцлалын гэрээ байгуулсан талаар тодорхойлсон албан бичиг
- vii. Хувь нийлүүлэгч болон толгой, охин компанийн тухай мэдээлэл, энэхүү холбоо хамаарлыг нотлох холбогдох баримтуудын хуулбар
- viii. Санхүүгийн баримт бичиг дээр гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
- ix. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан шалгуурыг хангаж буй нотлоход шаардлагатай гэж Биржээс үзсэн бусад баримт бичиг.

4.1.2. Энэ журмын 3 дугаар бүлэгт заасан шалгуурыг хангаж буй нотлох дараах төрийн байгууллагын лавлагаа тодорхойлолт: Үүнд:

- i. Татвар
- ii. Нийгмийн даатгал
- iii. Улсын бүртгэлийн газар
- iv. Цагдаагийн тодорхойлолт.

4.1.3. Биржид ирүүлсэн баримт бичигт нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд өргөдөл гаргагч нь энэ тухай ажлын 3 (гурав) хоногт багтан Биржид мэдэгдэж, холбогдох баримт бичгийг ирүүлнэ.

4.1.4. Өргөдөл гаргагч нь Биржид ирүүлэх бүх баримт бичгийг монгол хэл дээр бэлтгэн

ирүүлэх бөгөөд бичиг баримтын үнэн зөв байдлыг хариуцна. Шаардлагатай тохиолдолд баримт бичгийг эх хувийг монгол хэл дээр орчуулж, баталгаажуулан ирүүлнэ.

- 4.1.5. Өргөдөл гаргагчийг арилжааны гишүүнээр элсүүлэх эсэх тухай шийдвэр гаргах хүртэлх хугацаанд Биржээс энэ журмын 4.1.1 болон 4.1.2-т зааснаас бусад нэмэлт баримт бичиг шаардаж болох бөгөөд өргөдөл гаргагч нь тухайн нэмэлт баримт бичгийг заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.
- 4.1.6. Бирж нэмэлт баримт бичиг шаардсан бол энэ тухай өргөдөл гаргагч этгээдэд цахимаар эсвэл бичгээр мэдэгдэх ба өргөдөл гаргагч этгээд нэмэлт баримт бичгийг албан бичигт заасан хугацаанд, хэрэв хугацаа заагаагүй бол ажлын 5 (таван) өдрийн дотор гаргаж өгнө.
- 4.1.7. Өргөдөл гаргагч энэ журмын 4.1.1 болон 4.1.2-т заасан баримт бичгийг биржид бүрэн хүлээлгэн өгснөөр Бирж тухайн өргөдөл гаргагчийн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагаа эхэлсэнд тооцно.
- 4.1.8. Нэмэлт баримт бичиг ирүүлэхэд шаардлагатай хугацааг энэ журмын 4.2.3-т заасан шийдвэр гаргах хугацаанд оруулж тооцохгүй.
- 4.1.9. Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж нь дараах нөхцөлд өргөдөл гаргагчийн өргөдөл, түүний хавсралт баримт бичгийг хангалтгүй гэж үзэн баримт бичгийг хүсэлт гаргагчид буцаан өгөх, эсхүл нэмэлт шаардлага хүргүүлж болно. Үүнд:
 - i. Энэ журамд заасан шаардлагыг хангаагүй бол
 - ii. Энэ журамд заасан баримт бичиг нь агуулга болон бүрдэлтийн хувьд зөрчилтэй, эсвэл Биржээс шаардсан өргөдөлтэй холбоотой мэдээллийг бүрэн ирүүлээгүй бол
 - iii. Хүсэлт гаргасан этгээд, түүний нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан, энэ тухай хүсэлт гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарсан бол
 - iv. Хүсэлт гаргасан этгээд, түүний нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь тухайн компанийн үйл ажиллагаанд ноцтойгоор нөлөөлөхүйц хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох журмыг ноцтойгоор зөрчиж байсан, Хорооноос олгосон холбогдох тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон бол
 - v. Хүсэлт гаргасан этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эсхүл толгой компани нь сүүлийн 5 (таван) жилийн хугацаанд санхүүгийн гэмт хэрэгт холбогдон буруутай нь тогтоогдсон, эсхүл сэжиглэгдэн шалгагдаж байгаа бол
 - vi. Хүсэлт гаргасан этгээд Биржийн гишүүнээр элсэж, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх нь түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компанийн хувьд хуулиар хориглогдсон үйл

ажиллагаа гэж үзсэн бол.

4.2. Арилжааны гишүүнээр элсүүлэх

- 4.2.1. Өргөдөл гаргагчтай гэрээ байгуулах, гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгжийн санал дүгнэлтэд үндэслэн Биржийн гүйцэтгэх удирдлага гаргана.
- 4.2.2. Биржийн гүйцэтгэх удирдлага нь шийдвэр гаргахдаа ашиг сонирхол, нэгдмэл сонирхол, хамаарал бүхий этгээд зэрэг хүчин зүйлийг харгалзах бөгөөд энэ журамд заасан бүх шалгуурыг хангасан нь өргөдөл гаргагчтай Арилжааны гишүүнчлэлийн гэрээ байгуулах үндэслэл болохгүй.
- 4.2.3. Энэ журмын 4.1.1 болон 4.1.2-т заасан баримт бичгийг өргөдөл гаргагч Биржид бүрэн хүлээлгэж өгснөөс хойш ажлын 10 (арван) хоногт багтаан Биржийн гүйцэтгэх удирдлага тухайн этгээдийг арилжааны гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гаргана. Шаардлагатай тохиолдолд энэ журамд заасан хугацааг 1 (нэг) удаа ажлын 10 (арван) хоног хүртэл хугацаагаар сунгаж болно.
- 4.2.4. Арилжааны гишүүнээр элсүүлэх эсэх тухай шийдвэр гарснаар хойш ажлын 3 (гурав) хоногийн дотор Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж нь энэ тухай өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
- 4.2.5. Арилжааны гишүүнээр элсүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр хүлээн авсан өргөдөл гаргагчтай Арилжааны гишүүнчлэлийн гэрээ байгуулах ажлыг Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж зохион байгуулна.
- 4.2.6. Арилжааны гишүүнээр элсүүлэх шийдвэр гарсны дараа өргөдөл гаргагч нь Биржийн Шимтгэл, хураамжийн журамд заасны дагуу элсэлтийн хураамж төлнө.
- 4.2.7. Арилжааны гишүүний гэрээ байгуулсан өргөдөл гаргагч нь гишүүний кодоо авч, элсэлтийн хураамж төлж, Биржийн холбогдох системийг суулгаж, түүнийг ашиглах эрх авснаар Биржийн гишүүн болсон гэж үзнэ.
- 4.2.8. Арилжааны гишүүн гишүүний код авах, клирингийн системд холбогдох асуудлыг Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгжийн журамд заасны дагуу зохицуулна.
- 4.2.9. Арилжааны гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэр хүлээн авсан өргөдөл гаргагч нь тухайн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзсэн бол уг шийдвэрийн талаар Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлд дахин хянуулах хүсэлт гаргаж болно.
- 4.2.10. Биржийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл хүлээн авч, тухайн шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн тохиолдолд тухайн өргөдөл гаргагч нь шийдвэр гарснаас хуанлийн 6 (зургаа) сарын хугацаанд дахин арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргах эрхгүй байна.
- 4.2.11. Биржийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл хүлээн авч, тухайн шийдвэрийг өөрчлөхөөр шийдвэрлэсэн тохиолдолд тухайн өргөдөл гаргагч нь энэ журмын 4.2.3-д заасан

шийдвэрийг хүлээн авсанд тооцож, арилжааны гишүүнээр элсүүлэх үйл ажиллагааг энэ журамд заасны дагуу Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

4.3. Шимтгэл, хураамж

- 4.3.1. Арилжааны гишүүн нь Биржийн Шимтгэл, хураамжийн журамд заасны дагуу шимтгэл, хураамжийг тухайн журам эсхүл Биржийн нэхэмжлэхэд хугацаанд төлнө.
- 4.3.2. Арилжааны гишүүн нь Биржийн Шимтгэл, хураамжийн журамд заасны дагуу шимтгэл, хураамжийн хөнгөлөлтийг Биржийн эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу эдэлж болно.
- 4.3.3. Арилжааны гишүүний арилжаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлсэн нь тухайн гишүүнийг Биржид аливаа шимтгэл, хураамж төлөх үүргээс нь чөлөөлөх үндэслэл болохгүй.

ТАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

5.1. Арилжааны гишүүнд тавих хяналт

- 5.1.1. Бирж нь арилжааны гишүүдтэй байгуулсан гишүүнчлэлийн гэрээ болон холбогдох дүрэм, журмын хүрээнд арилжааны гишүүдэд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 5.1.2. Биржээс арилжааны гишүүнд тавих хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:
- i. Арилжаатай холбоотой үйл ажиллагаа холбогдох хууль, журам, шийдвэрийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг арилжааны системээр дамжуулан бодит цагийн горимоор;
 - ii. Бирж болон олон нийтэд мэдээлэхээр үүрэг хүлээсэн аливаа мэдээ, тайланг заасан хугацаанд хүргүүлж байгаа эсэхэд холбогдох журам, гэрээгээр тогтоосон хуваарийн дагуу
 - iii. Алдаатай, буруу мэдээлэл ирүүлсэн эсвэл арилжааны гишүүний үйл ажиллагаа холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд явагдахгүй байна гэж үзсэн тухай бүр.
- 5.1.3. Энэ журам болон бусад холбогдох баримт бичигт заасан аливаа шаардлага, эрх үүргийн хэрэгжилттэй танилцах зорилгоор Бирж шалгалт зохион байгуулж болно.
- 5.1.4. Бирж шалгалт зохион байгуулах шийдвэр гаргасан бол энэ тухай албан бичигт шалгалтын удирдамжийг хавсарган шалгалт эхлэхээс ажлын 3 (гурав) хоногийн өмнө арилжааны гишүүнд хүргүүлнэ.
- 5.1.5. Шалгалтын удирдамжийг хууль, тогтоомжийн дагуу боловсруулж, шалгалтын зорилго, хугацаа, хэлбэр, хамрах хүрээг тодорхой заасан байна.
- 5.1.6. Бирж шалгалтын тайланг арилжааны гишүүн болон шаардлагатай тохиолдолд Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах бөгөөд шалгалтын үр дүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.
- 5.1.7. Бирж нь хяналт, шалгалт явуулахтай холбогдсон нарийвчилсан харилцааг Биржийн Хяналтын журамд заасны дагуу зохицуулах бөгөөд арилжааны гишүүнд ногдуулах хариуцлага, хяналт шалгалтын дүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тус журамд заасан дагуу тодорхойлно.

ЗУРГАА. ГИШҮҮНЧЛЭЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ

6.1. Ерөнхий зүйл

6.1.1. Бирж нь арилжааны гишүүн нь холбогдох хууль, журмыг зөрчсөн эсвэл Биржийн шалгуурыг хангахгүй болсон гэж үзсэн бол түүний гишүүнчлэлийг түдгэлзүүлэх болон дуусгавар болгох хүртэл арга хэмжээ авч болно.

6.1.2. Арилжааны гишүүнчлэлийн гэрээнд зааснаас гадна дараах нөхцөл байдал үүссэн бол арилжааны гишүүний гишүүнчлэлийн гэрээг цуцлах үндэслэл болно. Үүнд:

- i. Биржийн дүрэм, журам болон эрх бүхий этгээдийн шийдвэрийг биелүүлээгүй, эсвэл энэ журамд заасан шалгуурыг хангахгүй гэдэг нь тогтоогдсон
- ii. Өөрийн санаачлагаар Арилжааны гишүүнчлэлийн гэрээг цуцлах хүсэлт гаргасан;
- iii. Биржид арилжааны гишүүний эд хөрөнгийг битүүмжилсэн тухай албан ёсны мэдээлэл эрх бүхий байгууллагаас ирсэн
- iv. Олон нийтийг төөрөгдүүлэх худал ташаа мэдээлэл тараасан, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг ноцтой хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал үүсгэсэн
- v. Биржийн арилжаатай холбоотой аливаа шаардлагыг биелүүлээгүй
- vi. Эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон
- vii. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу арилжааны гишүүнд дампуурлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж эхэлсэн
- viii. Гишүүнчлэлийн гэрээний хугацаа дуусгавар болсон.

6.1.3. Арилжааны гишүүнчлэлийн гэрээг цуцлах нөхцөл үүссэн тухай мэдээлэл Биржид ирсэн бол уг мэдээллийг Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж шалгаж, баталгаажуулсны үндсэн дээр тухайн арилжааны гишүүний Биржийн арилжаанд оролцох эрхийг нэн даруй түдгэлзүүлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2. Гишүүнчлэлийн гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэх

6.2.1. Энэ журамд заасны дагуу Арилжааны гишүүний гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, цуцлах нөхцөл байдал үүссэн гэж үзвэл Бирж энэ тухай мэдэгдлийг Арилжааны гишүүнд нэн даруй хүргүүлнэ.

6.2.2. Арилжааны гишүүн нь энэ журмын 6.2.1-т заасан мэдэгдэлд өөрөөр заагаагүй бол мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 (таван) өдрийн дотор уг зөрчлийг арилгах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд уг нөхцөл байдал, зөрчлийг арилгаагүй, энэ тухай холбогдох баримт бичиг, мэдээлэл ирүүлээгүй бол энэ нь Бирж тухайн

арилжааны гишүүний гишүүнчлэлийн эрхийг дуусгавар болгох тухай шийдвэр гаргах үндэслэл болно.

6.2.3. Арилжааны гишүүний эрхийг Биржийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр дуусгавар болгоно.

6.3. Арилжааны гишүүний хүсэлтээр гишүүнчлэлийн гэрээг цуцлах

6.3.1. Арилжааны гишүүний хүсэлтээр гишүүнчлэлийн гэрээг цуцлах өргөдлийг Бирж хүлээн авснаас хойш ажлын 10 (арван) өдрийн дотор шийдвэр гаргана.

6.3.2. Арилжааны гишүүнчлэлийн гэрээг цуцлах өргөдөл гаргасан арилжааны гишүүн нь өргөдөл гаргасан өдрөөс хойш ажлын 20 (хорин) өдрийн хугацаанд гишүүний үүргээ бүрэн биелүүлэх үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд багтаан Бирж болон Биржийн арилжаанд оролцсон өөрийн харилцагчтай бүх тооцоог дуусгасан байна.

ДОЛОО. ХАВСРАЛТ

Хавсралт 1. Өргөдлийн маягт

АРИЛЖААНЫ ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Хэнд:

“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д

Огноо:

Өргөдөл гаргагчийн нэр:

_____ (үнэт цаас компанийн нэр)-ийн Биржийн дараах арилжаанд оролцох эрхийг авч, Биржийн гишүүнээр элсэхээр энэхүү өргөдлийг гаргаж байна.

- Энгийн арилжаанд оролцох эрх
- Үүсмэл хэрэгслийн арилжаанд оролцох эрх

НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ
1. Үнэт цаасны компанийн ерөнхий мэдээлэл
1. Үнэт цаасны компанийн нэр
2. Улсын бүртгэлийн дугаар
3. Регистрийн дугаар
4. Үйл ажиллагааны чиглэл

5. Хаяг	
6. Холбогдох утас	
7. Цахим шуудангийн хаяг	
2. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл	
<input type="checkbox"/> Брокер	<input type="checkbox"/> Дилер
<input type="checkbox"/> Андеррайтер	
3. Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл	
Компанийн нэр	_____
Биржтэй харилцах ажилтны нэр	_____
Компанийн хаяг	_____
Холбогдох утас	_____
Цахим шуудангийн хаяг	_____
4. Өмнө нь арилжаа эрхлэх байгууллагад гишүүнээр элсэх өргөдөл гаргаж, татгалзсан хариу авч байсан эсэх	
Биржийн нэр	_____
Өргөдөл гаргасан огноо	_____
Татгалзсан шалтгаан	_____
ХОЁР. АЖИЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ	
1. Биржтэй харилцах, мэдээлэл солилцох ажилтны мэдээлэл	
Овог, нэр	_____
Албан тушаал	_____
Регистрийн дугаар	_____

<p>Гэрийн хаяг</p> <p>Утасны дугаар</p> <p>Цахим хаяг</p>	<p>_____</p> <p>_____</p> <p>_____</p>
<p>2. Арилжаанд оролцох, зуучлах ажилтны мэдээлэл</p>	
<p>Овог нэр</p> <p>Регистрийн дугаар</p> <p>Гэрийн хаяг</p> <p>Үнэт цаас гаргагч эсхүл толгой компанийн хувьцааг эзэмшиж байгаа эсэх</p> <p>Эзэмшлийн хувь хэмжээ</p>	<p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p>
<p>Овог нэр</p> <p>Регистрийн дугаар</p> <p>Гэрийн хаяг</p> <p>Үнэт цаас гаргагч эсхүл толгой компанийн хувьцааг эзэмшиж байгаа эсэх</p> <p>Эзэмшлийн хувь хэмжээ</p>	<p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p>
<p>Овог нэр</p> <p>Регистрийн дугаар</p> <p>Гэрийн хаяг</p> <p>Үнэт цаас гаргагч эсхүл толгой компанийн хувьцааг эзэмшиж байгаа эсэх</p> <p>Эзэмшлийн хувь хэмжээ</p>	<p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p>

ГУРАВ. ШАЛГУУР ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ МЭДЭЭЛЛҮҮД**1. Сүүлийн 3 жилийн орлого, ашгийн мэдээлэл**

	Орлого (мянган төгрөг)	Ашиг (мянган төгрөг)
_____ он		
_____ он		
_____ он		

2. Цэвэр хөрөнгийн дүн**3. Баталж, мөрдөж буй журмуудын жагсаалт**

1. Арилжааны гишүүнчлэлийн өргөдөл хянах хураамж _____ төгрөгийг Биржийн _____ банкны _____ тоот дансанд урьдчилан төлсөн болно.

2. Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргав.

(1) _____

(2) _____

(3) _____

Үнэт цаасны компанийг төлөөлж өргөдөл гаргасан:


Албан тушаал:

Овог нэр:

Гарын үсэг:

Хавсралт 2. Ажилтнуудын анкет

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ МЭДЭГДЭЛ

Ерөнхий мэдээлэл			
Овог:	_____		
Нэр:	_____		
Регистрийн дугаар:	_____		
Хүйс:	<input type="checkbox"/> эрэгтэй <input type="checkbox"/> эмэгтэй		
Үндэс угсаа:	_____		
Иргэний харьяалал:	_____		
Одоо эрхэлж буй ажил, албан тушаалын мэдээлэл			
Албан тушаал			
Ажилласан жил			
Ажлын байрны чиг үүргийн талаар товч			
Ажлын туршлага			
Компанийн нэр	Албан тушаал	Ажилласан жил	Ажлаас гарсан шалтгаан
Боловсрол			
Төгссөн сургууль	Хаана	Мэргэжил	Хугацаа

Шаардлагатай үед орлох ажилтны мэдээлэл				
Овог нэр	Албан тушаал	Чиг үүрэг	И-мэйл	Утас
Холбоо барих				
И-мэйл хаяг: _____ Гар утас, ажлын утас: _____ Гэрийн хаяг: _____				

Дээрх болон бусад баримт бичигт орсон миний мэдээлэл үнэн зөв болохыг үүгээр баталж байна.

Албан тушаал:

Овог нэр:

Гарын үсэг:

Хавсралт 3. Гарын үсгийн баталгааны маягт

ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГАА

Хэнд:

“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ” ХК-Д

Огноо:

Хэнээс:

1-р гарын үсэг		
Овог, нэр	Регистрийн дугаар	Албан тушаал
2-р гарын үсэг		
Овог, нэр	Регистрийн дугаар	Албан тушаал
3-р гарын үсэг		
Овог, нэр	Регистрийн дугаар	Албан тушаал
<i>Гишүүний тамга</i>		<i>Нотариатын тэмдэглэгээ</i>

Хавсралт 4. Арилжааны гишүүнчлэлийн гэрээний үлгэрчилсэн загвар

АРИЛЖААНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ГЭРЭЭ

20... оны-р сарын ...-ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг

нэг талаас Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сэнтрал Тауэр, 1309 тоот хаягт байрлах **Монголын Үнэт Цаасны Бирж ХК** (цаашид “Бирж” гэх) түүнийг төлөөлж **Гүйцэтгэх захирал** албан тушаалтай _____;

нөгөө талаас _____ дүүрэг, _____ дугаар хороо, _____ тоот хаягт байрлах _____

_____ (Улсын бүртгэлийн дугаар: _____, регистрийн дугаар: _____) түүнийг төлөөлж _____ албан тушаалтай _____ (цаашид “Арилжааны гишүүн ” гэх) нар байгуулав. Арилжааны гишүүн нь энэ гэрээгээр Биржийн гишүүн болохоор харилцан тохиролцов.

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ гэрээгээр Арилжааны гишүүн Биржийн арилжаанд оролцохтой холбоотой талуудын харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Биржээс баталсан дүрэм, журмаар зохицуулна.
- 1.3. Энэ гэрээнд ашиглагдсан нэр томъёог Биржийн холбогдох дүрэм, журамд заасны дагуу ойлгоно.

2. ТӨЛӨӨЛӨЛ, БАТАЛГАА

- 2.1. Арилжааны гишүүн энэ гэрээг байгуулснаар дараах зүйлсийг хүлээн зөвшөөрч баталгаажуулав. Үүнд:
 - (i) Арилжаанд оролцоход шаардлагатай бүхий л тусгай зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах эрхтэй хуулийн этгээд болохыг;
 - (ii) Биржийн гишүүнээр элсэж, ҮЦК-ийн холбогдох үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн болон хүний нөөц, техникийн чадамжтай болохыг;

- (iii) Энэ гэрээг байгуулснаар түүний бусад үйл ажиллагаатай харшлахгүй болохыг.
- 2.2. Энэ гэрээний 2.1-т зааснаас гадна Биржээс баталсан журам, шийдвэрт заасан бүхий л баталгааг гаргана.
- 2.3. Арилжааны гишүүн энэ гэрээ болон бусад холбогдох журамд заасан баталгааг хангаж чадахгүй болсон тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэнэ.

3. НУУЦЛАЛ

- 3.1. Талууд энэ гэрээний хэрэгжилтийн явцад мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.
- 3.2. Энэ гэрээний хэрэгжилттэй холбоотой хөрөнгө санхүү, ашиг, техникийн холбогдолтой баримт бичиг, мэдээлэл нь нууцлалд хамаарагдах бөгөөд гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.
- 3.3. Энэ гэрээний 3.1. болон 3.2.-т заасныг үл харгалзан Эрх бүхий байгууллагын шийдвэр болон Биржээс баталсан журам, шийдвэрт заасан шалтгаанаар аливаа нууц мэдээллийг бусдад задруулж болно.
- 3.4. Энэхүү гэрээ цуцлагдсан, дуусгавар болсноос хойш талууд нөгөө талын нууц мэдээллийг 3 жил хадгалах үүрэг хүлээнэ.

4. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 4.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба 1 (нэг) жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 4.2. Талууд энэ гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд гэрээний хувиуд хууль эрх зүйн хувьд ижил хүчинтэй байна.
- 4.3. Энэ гэрээ нь талуудын хооронд урьд өмнө байгуулсан болон цаашид байгуулах аливаа гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд тэдгээр гэрээ нь мөн энэ гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.
- 4.4. Талууд гэрээний нөгөө талд 1-ээс доошгүй сарын өмнө урьдчилан бичгээр мэдэгдсэнээр энэ гэрээг дуусгавар болгож болно.
- 4.5. Бирж холбогдох журамд заасан үндэслэлээр энэ гэрээг цуцалж болох бөгөөд энэ тухай шийдвэр гарсан даруйд Арилжааны гишүүнд мэдэгдэнэ.
- 4.6. Энэ гэрээ цуцлагдсан, дуусгавар болсноос хойш ажлын 15 өдрийн дотор талууд хоорондын тооцоог дуусгана.
- 4.7. Энэхүү гэрээний хугацаа дуусахаас ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Арилжааны гишүүн гэрээг сунгах тухай хүсэлтийг Биржид бичгээр гаргана. Уг хүсэлтийг үндэслэн Бирж гэрээг сунгах асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.8. Гишүүн гэрээ сунгах хүсэлт гаргаагүй, гаргасан боловч холбогдох шалгуур

үзүүлэлтийг хангаагүй байна гэж Бирж үзсэн бол энэхүү гэрээг сунгахгүй.

- 4.9 Биржийн бусад үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцооны асуудал нь гишүүнчлэлийн гэрээг дуусгавар болох үндэслэл болж болно.

5. ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 5.1. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа үл ойлголцолд Монгол Улсын хүчин төгөлдөр хууль, тогтоомж болон бусад эрх зүйн актуудыг хэрэглэнэ.
- 5.2. Гэрээний талууд гэрээг дагаж мөрдөх явцад үүссэн маргаан, саналын зөрчилдөөнийг харилцан тохиролцож, зөвшилцөх зарчмаар шийдвэрлэнэ.
- 5.3. Талууд зөвшилцөлд хүрээгүй бол тус маргааныг МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрын “Үнэт цаасны маргааныг шийдвэрлэх түргэвчилсэн дүрэм”-ийн дагуу тус арбитраар шийдвэрлүүлнэ. Арбитрын шийдвэр эцсийнх байна.

6. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

- 6.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.
- 6.2. Талууд энэ гэрээнд нэмэлт, эсхүл өөрчлөлт оруулсан бол тухайн нэмэлт, эсхүл өөрчлөлтийг хэрэгжүүлэх болон дуусгавар болгох хугацааг тодорхой заасан байна.

7. БУСАД

- 7.1. Бирж холбогдох журамд заасны дагуу арилжааны гишүүнд арилжааны болон шаардлагатай бусад дансыг нээж өгнө.
- 7.2. Арилжааны гишүүн нь Биржээс баталсан хүчин төгөлдөр журам болон бусад эрх зүйн актыг дагаж мөрдөнө.
- 7.3. Энэхүү гэрээний аль нэг заалт хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон нь бусад заалтын хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.
- 7.4. Энэхүү гэрээний эрх үүрэг, өр төлбөр, шаардах эрхийг гэрээний аль нэг тал аливаа гуравдагч этгээдэд зөвхөн нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр шилжүүлнэ. Энэ журмыг зөрчиж эрх үүрэг, өр төлбөр, шаардах эрх шилжүүлсэн аливаа шийдвэр, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Биржийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

(гарын үсэг)

Хаяг:

Утас:

Цахим шуудан:

Арилжааны гишүүнийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

(гарын үсэг)

Хаяг:

Утас:

Цахим шуудан:

Арилжааны гишүүнчлэлийн гэрээний хавсралт

Гишүүнчлэлийн хураамжийн хуваарь

Хураамж	Дүн	Төлөх огноо
Элсэлтийн хураамж	_____ төгрөг	20__/__/__
Жилийн хураамж	_____ төгрөг	20__/__/__
1-р улирлын хураамж	_____ төгрөг	20__/__/__
2-р улирлын хураамж	_____ төгрөг	20__/__/__
3-р улирлын хураамж	_____ төгрөг	20__/__/__
4-р улирлын хураамж	_____ төгрөг	20__/__/__

Мэдээлэл солилцох

Биржийн хаяг:	Гишүүний хаяг:
Цахим шуудан:	Цахим шуудан:
Утас:	Утас:
Факс:	Факс:

Хөнгөлөлт

Хөнгөлөлт үзүүлэх нөхцөл	Хөнгөлөлт үзүүлэх дүн